



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/191

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1, 27 дугаар зүйлийн 27.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар /Д.Давааням/-т үүрэг болгосугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2016 оны А/80 дугаар тушаалаар баталсан "Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам", 2021 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан "Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай" тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

170000899

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2021 оны 11 дүгээр сарын 03-ний өдрийн
А/191 дугаар тушаалын хавсралт

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид “гадаадын иргэн” гэх/-ийг Монгол Улсад гэр бүлийн, цагаачлах болон хувийн бусад хэлбэрээр оршин суух зөвшөөрөл олгох, сунгах, дахин олгох, гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэ журмын 1.1-д заасан асуудлыг хянан шийдвэрлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Засгийн газрын 2021 оны 194 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам” болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, чиг үүрэг

2.1. Зөвлөл дараахь бүрэлдэхүүнтэй байна:

Зөвлөлийн дарга:

- Байгууллагын дарга;

Нарийн бичгийн дарга:

- Нууц хариуцсан мэргэжилтэн;

Гишүүд:

- Дэд дарга;
- Захиргаа удирдлагын асуудал хариуцсан нэгжийн дарга;
- Виз, зөвшөөрлийн асуудал хариуцсан нэгжийн дарга;
- Иргэний харьяаллын асуудал хариуцсан нэгжийн дарга;
- Зөрчил шалган шийдвэрлэх асуудал хариуцсан нэгжийн дарга;
- Хяналт шинжилгээ, үнэлгээ, аудитын асуудал хариуцсан нэгжийн дарга.

2.2. Зөвлөлийн даргын эзгүйд түүнийг Дэд дарга орлоно.

2.3. Зөвлөлийн гишүүн эзгүй тохиолдолд Зөвлөлийн даргын зөвшөөрснөөр тухайн нэгжийн ахлах мэргэжилтнийг оролцуулж болно.

2.4. Зөвлөлийн ажиллах хэлбэр нь хуралдаан байх бөгөөд Зөвлөлийн дарга болон гишүүд саналын эрхтэй оролцоно.

2.5. Зөвлөл нь хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

2.5.1. Дор дурдсан оршин суух зөвшөөрөл хүссэн гадаадын иргэнд зөвшөөрөл олгох эсэх:

2.5.1.1. "G" цагаач;

2.5.1.2. "G-1" цагаачийн хамаарал бүхий этгээд;

2.5.1.3. "F1" Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж, гэрлэлтээ бүртгүүлсэн гадаадын иргэн;

2.5.1.4. "F1-1" Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж, гэрлэлтээ бүртгүүлсэн гадаадын иргэний эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх;

2.5.1.5. "F2-1" Монгол Улсын харьяатаас гарсан гадаадын иргэний хамаарал бүхий этгээд;

2.5.1.6. "F3-1" Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэний хамаарал бүхий этгээд;

2.5.1.7. "H1" Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан гадаадын иргэн;

2.5.1.8. "H1-1" Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан гадаадын иргэний хамаарал бүхий этгээд;

2.5.1.9. "H2-1" Монгол Улсын харьяатаас гарахгүйгээр гадаад улсын харьяат болсон иргэний хамаарал бүхий этгээд;

2.5.1.10. "H3" хувийн бусад зорилгоор буюу "Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам"-ын 4.1.1.1-4.1.6.4, 4.1.7-д зааснаас бусад зорилгоор оршин суух гадаадын иргэн;

2.5.1.11. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т заасан гадаадын иргэний цагаачлах зөвшөөрлийг дахин олгох;

2.5.2. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох эсэх;

2.5.3. Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх эсэх.

Гурав. Зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангах

3.1. Хуралдааны бэлтгэл ажлыг нарийн бичгийн дарга хариуцна.

3.2. Энэ журмын 2.5-д заасан асуудлын товч танилцуулгыг хариуцсан нэгжийн албан хаагч нь нарийн бичгийн даргад хуралдаан болохоос ажлын 2 /хоёр/-оос доошгүй өдрийн өмнө өгөх бөгөөд нарийн бичгийн дарга Зөвлөлийн даргад танилцуулан гишүүдэд тараана.

3.3. Нарийн бичгийн дарга зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын хүрээнд “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг зөвлөлийн гишүүдээс урьдчилан гаргуулна.

3.4. Зөвлөлийн гишүүн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тэмдэглэх тусгай дэвтэртэй байх ба түүнийг нарийн бичгийн дарга хадгална.

3.5. Хуралдаанд асуудал танилцуулах албан хаагч дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна:

3.5.1. Энэ журмын 2.5.1-д заасан гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгоход “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-д заасан бүрдүүлэх баримт бичгээс гадна хууль хяналтын байгууллагын санал болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;

3.5.2. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох бол “Олон улсын болон гадаад орны төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газрын зөвшөөрөл бүртгэл хариуцсан мэргэжилтний ажиллах заавар”-т заасан бүрдүүлэх баримт бичгээс гадна тагнуулын байгууллагын санал болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, хариуцсан нэгжийн санал;

3.5.3. Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэх бол Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2001 оны 100/32 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам”-д заасан бүрдүүлэх баримт бичиг, үрчлэн авагчтай хийсэн ярилцлагын тэмдэглэл;

3.5.4. Цагаачлан оршин суух зөвшөөрлөө дахин авах хүсэлт гаргасан гадаадын иргэний өргөдөл, 180 хоногоос дээш хугацаагаар гадаад улсад оршин суусан болохыг нотлох баримт бичгийн эх хувийг хуулбарын хамт /эмнэлгийн бичиг, сургууль, дамжаа төгссөн гэрчилгээ, тайлбар гэх мэт/, оршин суугаа хаягийн талаарх сум, хорооны Засаг даргын тодорхойлолт болон хууль хяналтын байгууллагын санал, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт.

Дөрөв. Зөвлөлийн хуралдаан

4.1. Зөвлөлийн ээлжит хуралдааныг сар бүрийн хоёр, дөрөв дэх долоо хоногийн лхагва гарагт хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн даргын шийдвэрээр ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна.

4.2. Нарийн бичгийн дарга хуралдааныг нээж, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулан, Зөвлөлийн дарга хуралдааныг даргалан явуулна.

4.3. Шаардлагатай тохиолдолд хяналт шалгалт хийсэн хяналтын улсын байцаагчаас тодруулга авна.

4.4. Хуралдаанд дуу, дүрс бичлэг, зураг зэрэг холбогдох мэдээ, мэдээлэл агуулсан танилцуулгыг ашиглаж болно.

4.5. Хуралдааны үйл явц, хэлэлцэж буй асуудлуудын талаар хариуцсан нэгжийн албан хаагчийн танилцуулга, гишүүдийн санал, шийдвэрийн талаар Зөвлөлийн нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд хуралдаан даргалагч болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

Тав. Зөвлөлийн шийдвэр, түүний хэрэгжилт

5.1. Зөвлөлийн хуралдаанд гишүүдийн олонхи ирснээр хурлын ирц хүчинтэйд тооцно.

5.2. Зөвлөл энэхүү журмын 2.5-д заасан асуудлыг хэлэлцэж хувь хүн, байгууллага тус бүрд нь “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзүүлсэн” шийдвэрийг тус тус гаргана.

5.3. Хуралдаанд оролцсон гишүүд хэлэлцсэн асуудлыг дараалал тус бүрээр нь илээр санал хурааж, оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргах бөгөөд санал тэнцсэн тохиолдолд зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэнэ.

5.4. Нарийн бичгийн дарга Зөвлөлийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг хувь хүн, байгууллага тус бүрээр нь ангилж, уг шийдвэрийг биелүүлэхийг хариуцсан нэгжийн даргад мэдэгдэнэ.

5.5. Хариуцсан нэгж нь Зөвлөлийн хуралдааны “зөвшөөрсөн”, “татгалзсан” шийдвэрийг байгууллагын даргын тушаалаар албажуулж хүсэлт гаргагчид ажлын 5 /тав/ өдөрт багтаан хариуг мэдэгдэнэ.

5.6. Зөвлөлийн хуралдаанаас “түдгэлзүүлсэн” шийдвэр гаргасан тохиолдолд тухайн асуудал хариуцсан нэгж холбогдох арга хэмжээг авч боломжит хугацаанд Зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

5.7. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн хувь хүн, байгууллагын баримт бичгийг хувийн хэрэг болон холбогдох материалд хавсаргана.

5.8. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг Нарийн бичгийн дарга архивын нэгж болгон байгууллагын архивт шилжүүлнэ.

6. Бусад

6.1. Зөвлөлийн хуралдааны шийдвэрийн дагуу гадаадын иргэнд олгосон оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтийг тухайн асуудал хариуцсан нэгжийн дарга хянаж энэ журмын 6.1.1, 6.1.2-д заасан гадаадын иргэний хувьд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг харгалзан сунгах хугацааг тогтооно.

6.1.1. Энэ журмын 2.5.1.2, 2.5.1.4-2.5.1.6, 2.5.1.9-д заасан хамаарал бүхий этгээд (эхнэр/нөхөр), 2.5.1.3-д заасан гадаадын иргэн;

6.1.2. Тухайн асуудал хариуцсан нэгжийн дарга шалгах шаардлагатай гэж үзсэн энэ журмын 6.2.1-д зааснаас бусад гадаадын иргэн;

6.2. Энэ журмын 6.1-д заасны дагуу тогтоосон хугацааг харгалзан байгууллагын даргын тушаалаар оршин суух зөвшөөрөл сунгах эсэхийг шийдвэрлэнэ.

6.3. Энэ журмын 2.5.1.3-д заасан гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-т заасан хугацаагаар сунгасан бол гэр бүлийн харилцаа, нөхцөл байдлыг тогтоох зорилгоор хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж болно.

6.4. Гадаадын иргэнд дараах оршин суух зөвшөөрөл олгох, сунгах асуудлыг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхгүйгээр тухайн асуудал хариуцсан нэгжийн дарга, ахлах мэргэжилтэн шийдвэрлэнэ:

6.4.1. “F2” Монгол Улсын харьяатаас гарсан гадаадын иргэн;

6.4.2. “F3” Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэн;

6.4.3. “H2” Монгол Улсын харьяатаас гарахгүйгээр гадаад улсын харьяат болсон иргэн;

6.4.4. Цагаач, гэр бүлийн болон хувийн бусад хэлбэрээр оршин суух 18 хүртэлх насны гадаадын иргэн;

oOo